

Хавсралт В

Байгаль орчны эрхийн төлөө тэмцэхдээ хуулийг хэрхэн ашиглах вэ?



Хүний эрх болон эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх хэмээн нэрлэгддэг эрхийг олон улс оронд хуулиар хамгаалдаг. Энэ номын бүлэг бүрт хүмүүс эрхээ хамгаалуулахын төлөө хэрхэн хамтран тэмцдэг тухай болон хэрхэн ажилладгийг үзүүлсэн билээ. Харин энэ хэсэгт эрүүл аюулгүй амьдрах эрхийнхээ төлөө тэмцэхийг хүссэн хүмүүст шүүхийн зарга мэдүүлж, хуулийн замаар тэмцэхэд нь туслах мэдээллийг орууллаа. Мөн үүнд орон нутгийнхаа болон үндэсний шүүх засаглалын шугамаар эрхээ хамгаалуулж чадахгүй байгаа иргэд засгийн газар нь ямар нэг арга хэмжээ авахгүй байгаа бол гадаадаас хэрхэн тусламж авах талаар оруулав.

Өөрсдийнхөө эрүүл аюулгүй байдлын төлөө тэмцэж байгаа иргэдийн эсрэг засгийн газар хүч хэрэглэх, орон нутагт байгаа баялгийг хүмүүс байгааг үл харгалзан авч ашиглах нь олон тохиолдоно. Том төслүүд хүмүүсийг суурьшдаг газраас нь нүүлгэх зайлуулах, тэр хавьд нь аймшигт хор хүргэх, нийтийн эрүүл мэндэд аюул учруулах, хүнд өвчнийг үүсгэх хор үйлдвэрлэх зэргээр хүний эрх болон эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг олон янзаар зөрчдөг. Том корпорациуд заримдаа маш их мөнгөтэй учраас засгийн газруудыг хуулиа хэрэгжүүлэхийг нь болиулах хүртэл нөлөөлж чаддаг юм.

Орон нутаг болон үндэсний хууль тогтоомжууд хэрэгжихгүй нөхцөлд таныг болон орон нутгийг тань олон улсын хууль хамгаалж болно. Эрүүл аюулгүй амьдрах эрх нь шинэ ойлголт бөгөөд энэ эрхийг хэрхэн хэрэгжүүлэх талаар улс орнууд дөнгөж дадлага туршлага сууж эхэлж байна. Ийм учраас эрүүл аюулгүй орчны төлөө хийсэн хуулийн зарга бүр хойшид хүмүүсийн эрхийг хамгаалахад хамгийн чухал ач холбогдолтой юм.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ

Үйлдвэрлэл болгон аливаа хөгжлийн төслүүд нь байгаль орчинд маш их хямрал учруулдаг учир олон засгийн газрууд, үйлдвэрийн газрууд болон хөгжлийн агентлагууд аливаа нэгэн хөгжлийн төслийг хийхийн тулд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ заавал хийх шаардлага тавьдаг болж байна. Энэ нь тухайн бүтээн байгуулалт, зам, уул уурхай, онгоцны буудал болон бусад үйлдвэрлэлийн хөгжлийн бүтээн байгуулалт нь хүн, амьтан, газар, ус болон агаарын чанарт ямар өөрчлөлт оруулах талаар дүрслэн бичдэг баримт бичиг юм.

Нөлөөллийн үнэлгээний баримт бичигт орон нутгийн хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх, соёлын өв нөөцийг алдах, уламжлалт амьдралын хэв маягийг эвдэх, түүхийн болон шашны ач холбогдолтой газар нутгийг эвдэх зэрэг янз бүрийн нийгмийн асуудлыг тусгаж өгч болдог. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд төслийг илүү аюулгүй ямар аргаар хийж болохыг бас зааж өгч болдог. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг корпорациуд дангаараа болон орон нутгийн иргэд, засгийн газрын хүмүүстэй хамтран хийж болно.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ яаж ажилладаг вэ?


Үүнд хоёр үндсэн үйл ажиллагаа ордог:

1. Тухайн төслийн үзүүлэх нөлөөллүүдийг судалсан судалгаа ба түүнийг тайлбарлан бичсэн тайлан. Энэ нь ихэвчлэн тухайн төсөл хэрэгжүүлэх компани хариуцаж хийх ба үүнд олон нийт оролцох эсэхээ өөрсдөө шийддэг.
2. Төсөл эхлэхээс өмнө байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хэлэлцэх нийтийн хурлыг зохион байгуулж төслийн явцад олон нийтээр төслийг үнэлүүлдэг.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ нь болгоомжлох зарчим дээр суурилагдаж байвал хамгийн сайн байдаг. Хэрэв үүнд тухайн төслөөс гарах аюулыг үзүүлсэн байвал төслийн төлөвлөгөөг зогсоох болон өөрчилж болно.

Гэхдээ ихэнхдээ үнэлгээг хийхдээ байгальд болон хүнд ямар ч хоргүй гэж харуулахыг хүсдэг. Мөн ямар ч хоргүй гэж дүгнэсэн байдаг. Ихэнх компаниуд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээ олон нийтийг оролцуулахгүйгээр эхлээд бичдэг. Бичих шатандаа олон нийтийн оролцоог хязгаарлах нь их. Тэр ч байтугай зарим компаниуд байгаль орчны нөлөөллийг хэлэлцэх уулзалтын зарыг тараадаггүй бөгөөд тэд үүнд хүмүүсийг яаж оролцуулахгүй байх вэ гэж хичээдэг.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний шударга бус энэ процесст зөвхөн компани болон засгийн газрын агентлагууд оролцдог бөгөөд тухайн төслийг олон нийтэд мэдэгдэлгүй эхлүүлж, олон нийтэд мэдэгдэлгүй үргэлжлүүлж, бас ийн зогсоодог. Олон нийт байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нийтэд нь оролцож чаддаггүй. Гэлээ ч гэсэн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ нь олон нийт, засгийн газарт төлөвлөж буй ажлуудынх нь талаар хяналт тавих чухал хэрэгсэл болдог юм.



Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийт хэрхэн нөлөө үзүүлж чадах вэ?

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд оролцож эрхээ эдлэхийн өмнө та нилээд их мэдээллийг олон талаас авах хэрэгтэй. Ялангуяа компаниас болон эргэн тойрныхноос тухайн төслөөс гарах үр дагаврын тухай мэдээлэл авах хэрэгтэй.

Ихэвчлэн хүмүүс үгээ хэлэхээс өмнө төслийн талаар шийдвэр нь бараг гарсан байдаг. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд оролцох нь хүмүүст зохион байгуулалттай болж, орон нутгийнхаа нөөцийг удаан хугацаанд хадгалахад нь тусална. Аюултай төлөвлөгөөг зогсоох боломжгүй болсон ч гэсэн байгаль орчны үнэлгээний талаар хүмүүст мэдээлэл өгч, зохион байгуулалтад ороход нь, орон нутаг иргэдээ хамгаалахад нь тусална.



Иргэдийг оролцуул гэж шаард

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд тухайн нутгийн иргэд оролцоно гэж шаардлага тавьж болно. Зарим засгийн газрын байгууллагууд орон нутгийн хүмүүсийг байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд төлөөлөл болгон оруулдаг. ТББ, хуульч зэрэг мэдээлэлтэй хүмүүс орж, төлөөлж оролцон асуулт асууж болно.

Хэрэв олон нийтийн төлөөлөгч нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээний үйл явцад оролцож байвал тэд орон нутгийн иргэдийн хуралд мэдээлэл хийн, компанийн төлөвлөлтийн талаар ярьж өгнө. Иргэдийн оролцоо нь олон нийтэд өөрсдийнх нь эрх үүргийг илүү сайн ойлгуулж, тухайн төслөөс гарч болох аюул, урьдчилан сэргийлж болох болгоомжлолуудыг хүмүүст мэдээлнэ.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг бүхэлд нь олж ав

Орон нутгийнхан байгаль орчны нөлөөллийн үнэлгээг бүтнээр нь нягталж унших эрхтэй. Тэдэнд үнэлгээний хэсэгчилсэн болон товчилсон хувилбар хангалтгүй юм.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд байгаль орчин, эрүүл мэнд, цэвэрлэгээ хийх хэсэг багтдаг. Эдгээр хэсгүүдэд компаниуд бусад мэдэгдэхийг хүсэхгүй зүйлээ бичсэн байж болно. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд дурьдсан асуудлууд болон үнэлгээнд дурьдагдаагүй бусад асуудлуудыг хэвлэл мэдээллээр тарааж, засгийн газарт мэдэгдэж, олон нийтийн хуралд мэдээлж болох ба энэ нь аюултай үйл ажиллагааг зогсооход тусална. Байгаль орчны байгууллага болон НҮБ зэрэг олон улсын байгууллагатай мэдээллээ хуваалцаж, шинэ уурхай, байгууламжийн төслүүдэд олон нийт эргэлзэж байгааг мэдээлж болно.

Орон нутгийн иргэд уул уурхайн төслийг эсэргүүцэв

Эквадорын Андрес уулсын дагуу ургадаг өтгөн ой модонд жижиг газар тариалан эрхлэн амьдардаг Жунин хэмээх нутгийн иргэд байдаг. Эндхийн хүмүүс хэдийгээр ядуу ч хэдэн зуун жилийн турш газрыг арчилж сурч, газраас хүнсээ залгуулсаар иржээ. Саяхан жунин хүмүүс түүхэндээ байгаагүй том асуудалтай тулгарчээ.

Тэдний нутагт Өмнөд Африкийн хамгийн том ил зэсийн уурхай байгуулахаар шийдсэн байна. Японы нэгэн зэсийн уурхай газрыг ухахаар ирэхэд жунинууд газраа хордоно гэдгийг мэдэж байв. Гэвч уурхайнхан зам, гүүр, сургууль барина гэж амлан жунин хүмүүсийг уул уурхайгаас амьдралаа дээшлүүлэх боломжтой гэж ятгажээ.

Том компани зэсээ ухаж эхлээд удаагүй байхад жуниний хүмүүс уурхайн хог хаягдлаар хордож байгааг мэдэжээ. Удалгүй хүмүүс арьсны янз бүрийн өвчин болон бусад элдэв өвчнөөр өвдөх болов. Нутгийн иргэд уурхайг бохирдлоо зогсоо гэж хүсчээ. Гэвч тэгээгүй тул жунин хүмүүс эсэргүүцлийн хөдөлгөөнийг өрнүүлжээ.

Уурхайчдыг амарч байх өдөр нь тосгоны хэдэн зуун хүмүүс уурхай дээр ирж тэдний багаж хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмж болон үнэ цэнэтэй зүйлсийг нь хураан авч, уурхайн тосгоныг шатаажээ. Компани нутгийнхны эсэргүүцлийг ойлгон нутгаас гарсан ч удалгүй Канадын компанид уурхайгаа заржээ. Тэд нутгийнхныг дотор нь хагалах арга хайжээ. Тэд жунин хүмүүст ихээхэн мөнгө амлаж “газраа зараач” гэжээ. Зарим нь газраа зарж зарим нь татгалзжээ.

Компанийнхан үүнээс болж орон нутагт зөрчил болно гэж мэдэж байв. Мөн тэд эмч явуулж компанийг дэмжинэ гэсэн хүмүүсийг эмчилж байлаа. Үүнийг Эквадоруос гадагш мэдээлж чадсаны дараа олон улсын эмч нарыг жунинчууд руу явуулж, үзэл бодол харгалзалгүй эмчилжээ.

Эквадорын хуулиар аливаа ажил эхлэхээс өмнө Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх ёстой ба үүнийг тосгоныхон тэмцэлдээ хэрэглэсэн байна. Тосгоныхон байгаль орчны үнэлгээг буруу хийснийг мэдэж байсан ба зөв хийсэн бол засгийн газар тэнд уурхай байгуулахыг зөвшөөрөхгүй байх байсан гэж тэмцжээ. Тэд бас хэрэв байгаль орчны нөлөөллийн үнэлгээг үнэнчээр хийсэн байсан бол зэсийн уурхай нь ойр хавьд байсан хүмүүсийг нүүлгэн шилжүүлж, газрыг бохирдуулж, газрыг элээн сувгийг бохирдуулж, хүнд металлыг орчинд тараана гэдгийг мэдээлэх ёстой байсан гэдгийг мэдэж байв.

Жунины хүмүүс хуулийг яаж өөрсдөдөө хэрэглэх талаар судалж мэдэжээ. Компани байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийсэн гэхэд засгийн газар түүнийг бүрэн бус гэж буцаав. Жунины хүмүүс компанийн машиныг нутагтаа оруулахгүй гэж замыг бөглөх шууд арга хэмжээ авав. Орон нутгийн иргэд өөрсдийнхөө газар нутгийг уул уурхайгүй бүс болгон зарлахыг шаардав. Янз бүрийн тактик ашигласаар жунины хүмүүс задгай зэсийн уурхай байгуулахын эсрэг тэмцэж амжилтад хүрсэн юм. Ингэснээр тэд өөрсдийн орон гэр, ой мод, усаа хамгаалж үлдсэн юм.

Бид зохион байгуулалтаа үргэлжлүүлсэн. Зарим тосгоныхон биднийг дэмжиж сонин гаргасан.



Олон нийтэд тулгуурласан байгаль орчны нөлөөллийн үнэлгээ

Энэ нь тосгон суурин, бүс нутгийн хэмжээнд байгаль орчин, нөөц, агаар, хоол хүнс, амьтан, ус, ойн бүтээгдэхүүн, эмийн ургамал, ариун газар нутаг болон бусад зүйлсийг хэрхэн ашиглан хамгаалж арвижуулах талаар нийтийн ойлголттой болоход тусалдаг баримт бичиг юм.

Энэ баримт бичиг нь олон нийтэд нутагт нь байгаа нөөц бололцоог хэрхэн ашиглах талаар ойлголт өгөөд зогсохгүй түүнд таарах буруу ойлголт зөвшлүүдийг тайлбарлаж ойлгоход нь тусална. Мөн энэ ажил нь тухайн орон нутагт засгийн газар, корпорациудын эсрэг олон нийтийн дуу хоолойг нэгтгэн гаргахад хэрэглэгдэнэ. Мөн ямар нэг үйлдвэрлэл хүмүүсийн дунд хагарал үүсгэж, ус ойн нөөцийг хэрхэн ашиглах талаар эсрэг байр суурь гарсан нөхцөлд хүмүүсийг нэгэн зүгт нэгтгэхэд тусална. Олон нийтэд тулгуурласан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ нь хүмүүс цугларч, асуудлаа яаж шийдэх вэ гэх энгийн хурлаар эхэлнэ.

Илүү нарийвчилсан үнэлгээнд орон нутгийн судалгаа, янз бүрийн хөрш орон нутагтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, дэмжигч байгууллагуудын үүргийг оруулж болно. Олон нийтэд тулгуурласан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ нь засгийн газар, компаниудынхаас өөр юм. Юуны өмнө түүнийг заавал хуулиар гаргах ёсгүй. Харин хуулиар заагаагүй ч олон нийт өөрсдөө соёл, орон нутгийн эрүүл ахуйд санаа зовсондоо сайн дураар гаргадаг бичиг юм.

Энэ нь компаниудын гаргадаг үнэлгээ шиг шинжлэх ухааны нарийн хэллэгтэй байх албагүй ба хүмүүст шууд ойлгогдох энгийн хэллэгтэй байх ёстой. Олон нийтэд тулгуурласан байгаль орчны нөлөөллийн үнэлгээ нь бусад байгаль орчны үнэлгээнүүдийн дэргэд үнэлгээг өөрөөр хийж болох юм гэдгийг харуулж харьцуулах баримт бичиг юм.

Энэ номыг уншсан идэвхтэнүүд газрын зураг яаж хийх, жүжигчилсэн тоглолт яаж хийх, хогийн цэгээр явган аялах, усыг хэрхэн хамгаалах зэрэг янз бүрийн мэдээллээр суралцсан байгаа. Эдгээр нь танд олон нийтэд тулгуурласан нөлөөллийн үнэлгээ гаргахад туслах юм.

Зарга хийх

Байгаль орчны эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ хамгаалж шударга ёсыг тогтоох нэг арга нь компаниудыг үндэсний болон олон улсын хууль зөрчиж байна гэж шүүхээр заргалдан ялах явдал юм. Байгаль орчныг бохирдуулж буй компаниудын эсрэг заргыг амжилттай хийх нь хохирсон хүмүүсийг хамгаалаад зогсохгүй цаашид олон газрыг бохирдуулахаас хамгаалж чаддаг.

Хуулийн зарга таны орон нутагт тусалж чадах уу?

Байгаль орчны шударга ёсыг тогтоохын төлөөх тэмцэлд олон зарга амжилтад хүрч байсан юм.

Гэхдээ хуулийн зарга хийх нь маш үнэтэй байдаг ба олон жил шаардагддаг. Гэвч эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалсан хууль тухайн оронд байдаг ч тэр хуулиар шүүхэд заргаа авах маш хэцүү байдаг. Байгаль орчин, хүний эрхийн тухай хуулийг олон удаа хэрэглэж үзээгүй бол шүүгч, хуульч нар тэр хуулийг яаж ашиглахаа мэддэггүй.

Мөн олон оронд, ялангуяа корпорациуд хүчтэй байдаг оронд шүүгч, улс төрчдийн дунд байдаг авлигаас болоод ядуу орон нутгийн иргэд өөрсдийнхөө эрхийг хамгаалж чаддаггүй. Шүүхэд очиж байгаа заргын цөөхөн нь ялж, ихэнх нь ялагдаж байдаг. Компани, үйлдвэрлэл, засгийн газрын эсрэг зарга мэдүүлэхээсээ өмнө хэд хэдэн зүйлийг тооцон байх ёстой.

Өөрсдийн зорилгоо эхлээд бод

Шүүхээр зарга хийж байх үед яг ямар үр дүнд хүрэхийг хүсч байгаагаа мэдэх нь чухал. Дараа нь энэ үр дүнд хүрэхийн тулд шүүхээр явах нь зөв арга эсэхийг шийд. Та компанийг:

- Нефть асгарсан газраа цэвэрлэж, бусад хортой бохирдлыг арилгаасай гэж хүсч байна уу?
- Хүмүүсийн эрүүл мэнд, газар, нөөц хөрөнгөд нь учирсан хохирлыг төлөөсэй гэж бодож байна уу?
- Компанийг хаалгаж нутгаасаа гаргая гэж хүсч байна уу?

Хуулийн хүрээнд шүүхээр тэмцэх нь олон нийтийг идэвхжүүлж гэгээрүүлэх хэрэгсэл болдог. Харин бойкот зарлах, суулт хийж, нийтийн мэдээллийн хэрэгслээр тэмцэх нь улс төрийн аргаар гэрээ хэлцэл хийлгэж, зарим үед хуулийн тэмцлээс хурдан хугацаанд үр дүнд хүрдэг.

Та орон нутагтаа тэмцэл хийхдээ хурдан үр дүнд хүрэхийг хүсч байна уу, эсвэл шүүхээр явж үр дүнд хүрэхийг хүсч байна уу гэдгээ тооц. Мөн хууль шүүхийн болон шууд тэмцлээ хослуулах уу гэдгээ бод.



Шүүх дээр ялж чадахгүй бол хуулийн замаар тэмцэх нь хэрэгтэй юу?

Мэдээж хэрэг та шүүх дээр ялахыг хүсч байгаа. Гэхдээ хэрэв ялж чадахгүй бол энэ зарга нь танд муугаар нөлөөлөх үү гэдгийг бод. Заримдаа амжилтгүй ч хамаагүй зарга хийх нь тухайн орон нутгийн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулдаг. Мөн хэрэв эрүүл аюулгүй байдлын тэмцэл нь танай нутагт болон танай оронд амжилтгүй болоход олон улсын буюу НҮБ-д амжилттай болох боломжтой. Гэхдээ асуудлыг ингэж шийдэж чадахгүй байлаа ч олон нийтийн анхаарлыг хандуулдаг.

Гэхдээ нь энэ нь нөөц их шаарддаг. Заримдаа амжилтгүй болсон шүүхийн ажиллагаа асуудлыг хурцатгадаг. Нэг зарга амжилтгүй болсноос шүүгч, хуульчид цаашид тоохгүй болж эхэлдэг. Мөн суулт хийх, мөнгө шаардах зэрэг сөрөг сурталчилгаа газар авдаг. Зохион байгуулалт буруудахад тохиолддогийн нэгэн адил амжилтгүй шүүхийн зарга олон нийтийг бутрахад хүргэнэ.

Хэн заргыг шүүхэд мэдүүлэх вэ?

Хохирч гэмтсэн хохирогч болон түүний гэр бүлийнхэн, эсвэл бүхэл бүтэн нутаг хамт олноороо хууль шүүхээс гарах эрсдлийг даван туулах чадвартай байх ёстой. Ихэвчлэн хохирогчоос өөр хүн зарга үүсгэж болдоггүй. Хохирогч болон түүнтэй хамтрахыг хүссэн хүмүүс хамтран нэрээ оруулан зарга үүсгэж болно.

Хохирсон гэдгийг юу батлах вэ?

Шүүхийн заргыг амжилттай болгохын тулд та 2 зүйлийг баталсан байх ёстой. Үүнд, хохирогч биеийн болон эдийн засгийн хохирол амссан байх. Компаниуд, үйлдвэрүүд үүнийг үүсгэсэн гэдгийг нотолно.

Хэрэв танд хангалттай нотлох баримт байхгүй бол заргыг амжилтгүй болгоно. Хэрэв үүнийг компани хийсэн нь ил байгаа ч түүнийг батлах баримтгүй бол та шүүхэд ялагдах боломжтой.

Нотлох баримт олдох уу?

Шүүх дээр авчирч болохуйц нотлох баримтыг л шүүх ашиглаж чадна. Та шүүх дээр нотлох баримтыг авчрахын тулд үүний тухай ярьж чадах гэрчүүдийг олох хэрэгтэй. Тэд хохирсон талаараа судалгаа, зураг, эмнэлгийн бүртгэл мэдээлэл, компанийн эсрэг хэрэглэж болох бусад материалыг авчрах ёстой.

Хохирсныг нотлох нь маш хэцүү байж болно. Жишээ нь, компани эмч хөлсөлж аваад компаниас гарсан химийн бодис нөлөө үзүүлээгүй гэж, тухайн өвчин архи ууж тамхи татсанаас болсон гэж нотлохыг оролдоно. Гэвч хууль ёсоор баталж чадахгүй ч гэсэн энгийн ойлголтоор хохирогч компаниас болж хорт хавдар туссан гэж мэдэж байж болно. Гол нь үүнийг баримтжуулахад маш их хүчин чармайлт хэрэгтэй.


Өвчин хохирлыг хэн, юу үүсгэв?

Байгаль орчноос үүссэн хохирлын заргыг мэдүүлэхдээ хувь хүмүүс нь корпорацууд болон заримдаа засгийн газрын эсрэг ч мэдүүлж болно.

Заргыг үндэстэн дамнасан корпорацийн эсрэг мэдүүлж байна уу?

Үндэстэн дамнасан корпорациуд ихэвчлэн олон оронд офистой байдаг. Үүний эсрэг амжилттай зарга мэдүүлэхийн тулд түүний аюул осол гаргасан улс оронд болон толгой компани байдаг газар руу давхар мэдээлэх нь зайлшгүй шаардлагатай. Энэ нь үнэ өртөг ихтэй ч хийж болох асуудал юм.

Үндэстэн дамнасан корпорациуд нь тус орондоо салбартай байдаг. Ихэвчлэн тэр салбар компанийг заргалдах нь гадаад эзнийг шүүхэд дуудахаас хялбар байдаг. Жишээ нь, АНУ-ын Шеврон компани Нигерийн гурвалжинг бохирдуулсан байхад АНУ-ын компанийг биш Шевроны охин компанийг шүүхэд өгсөн юм. Ингээд дэлхий даяар түүний эсрэг сурталчилж, тухайн байгууллагыг үйл ажиллагааныхаа хэв загвар, процедурыг өөрчил гэж шаардсан юм.



Тооцож үзвэл зохих бусад асуудлууд

- **Осол, аюул бохирдлыг саяхан гаргав уу?** Осол аюул тохиолдсоноос хойш 10 жил өнгөрөхөөс өмнө богино хугацаанд зарга үүсгэх хэрэгтэй байдаг. Хэрэв хорт хавдар зэрэг үхэх аюултай өвчин туссан, олон жилийн дараа гардаг өвчин туссан бол хуулийн хугацаа дууссаны дараа заргалдах нь хэцүү байдаг.
- **Зарга үүсгэгчид өөрсдийн гэрч, хуульч нарыг авчирсан уу, тэд аюулгүй байдлаа эрсдэлд оруулах уу?** Олон корпорациуд, засгийн газар өөрсдийн эрх мэдэл хөрөнгийг авч үлдэхийн тулд хүчирхийлэл аллага ч зохион байгуулдаг. Зарга тэмцэл хийж буй хүмүүс амь дүйсэн ажил хийж байдаг.
- **Хуулийн заргын явцад төлбөр хийх мөнгө байгаа юу?** Шүүхийн хураамж, өмгөөлөгчийн төлбөр, олон улсын аялал, утасны дуудлага, нотлох баримт цуглуулах болон бусад жижиг зардлууд байнга үүсч нэмэгдэж байдаг юм.
- **Энэ зарга дээр та олон жил ажиллах бололцоо байгаа юу.** Ямарваа зарга нь 3-10 жил, түүнээс ч удаан байж болно. Заримдаа хэрэг нь шийдэгдэж байхад хохирогч нь нас барах нь бий. Олон оронд шүүхийн зарга их удаан хугацаатайгаар үргэлжилдэг тул хүнд өвчтэй хүмүүс хурдан аргаар заргаа шийдүүлэх замыг сонгодог. Энэ нь арбитрийн шүүхийн арга юм. АНУ-ын Калифорни мужид гарсан химийн хордлогын хохирогч нарт тусалсан Эрин Брокович гэдэг эмэгтэй чухамхүү энэ арбитрийн шүүхийн ачаар бүхэл бүтэн тосгоны хохирогч нарт нөхөн төлбөр хурдан гаргуулж өгч чадсан байдаг. Энэ тэмцлийн тухай Эрин Брокович гэдэг кинл хийжээ.

Олон улсын хуулийг ашиглах

НҮБ-ын гишүүн олон орнууд хүний эрх, хүмүүсийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалсан олон хууль конвенцийг баталж гарын үсэг зурсан. Хүний эрх нь хүн бүрт ижил заяагдсан ба түүнийг хэн ч булаан авч чадахгүй. Үүнийг ихэнх улс оронд хүлээн зөвшөөрдөг ч хамгаалж эдлэхийн тулд хүмүүс шаардлага тавих ёстой. Ингэхгүй бол дотоодын болон олон улсын хууль, конвенц ашиглагдахгүй үлддэг.



Олон улсын гэрээ хэлэлцээр

Эдгээр нь хүний эрх болон байгаль орчныг хамгаалж гардаг. Харамсалтай нь хувь хүн, нийгмийн бүлэг эрхээ зөрчигдсөний дараа л эсэргүүцдэг. Хувь хүн ба нийгмийн бүлэг нь олон улсын хэмжээнд шууд нөлөөлж чадахгүй, зөвхөн төрийн төлөөлөл үүнийг хийх ёстой ба тэд энэ үүргээ ховор гүйцэтгэнэ.

Мөн олон улсын гэрээг хэрэгжүүлэхдээ зөвхөн төр улсын эсрэг арга хэмжээ авч чадахаас үндэстэн дамжсан корпорациудад нөлөөлж чаддаггүй. Тухайн улсынх нь өмнөөс тус компанид шийтгэл оногдуулдаг. Мөн олон улсын гэрээнүүдийг тухайн улс хуулийнхаа хүрээнд хэрэгжүүлдэг. Олон улсын хуулийг мэдэх нь хүний эрхээ хамгаалахад тань тусалдаг. Хэрэв хүмүүс эрхээ мэддэг, бусад орнууд өөрсдийнх нь эрхийг хэрхэн хүндлэдэгийг мэддэг байх юм бол тэд эрхээ эдэлж засгийн газраа хянаж чадна.

Доорх жагсаалтад байгаа олон улсын гэрээнүүд нь хүний эрх болон байгаль орчныг хамгаалсан гэрээнүүд юм. Түүний хаяган дор байгаа веб сайт руу орж эдгээр эрхүүдээ мэдэж авч болно.

The United Nations Charter
www.un.org/aboutun/charter/

The Universal Declaration of Human Rights
www.un.org/Overview/rights.html

The Convention on the Rights of the Child
www.unhcr.ch/html/menu3/b/k2crc.htm
www.unicef.org/crc/

The United Nations Framework Convention on Climate Change
unfccc.int/2860.php

The Convention on Biological Diversity
www.biodiv.org/default.shtml
www.iisd.ca/biodiv/cbdintro.html

The Declaration on the Right to Development
www.unhcr.ch/html/menu3/b/74.htm

The International Covenant on Economic, Social and Cultural Rights
www.unhcr.ch/html/menu3/b/a_ceschr.htm

The United Nations Declaration on Social Progress and Development
www.unhcr.ch/html/menu3/b/m_progre.htm

The United Nations Vancouver Declaration on Human Settlements
www.un-documents.net/van-dec.htm

The Stockholm Convention on the Elimination of POPs
www.pops.int
www.ipen.org

The Basel Convention on the Control of Transboundary Movements of Hazardous Wastes and Their Disposal
www.basel.int/text/con-e.htm
www.ban.org

The Bamako Convention on the Ban of the Import into Africa and the Control of Transboundary Movement of Hazardous Wastes within Africa
www.londonconvention.org/Bamako.htm
www.ban.org/Library/bamako_treaty.htm

The Rotterdam Convention on the Prior Informed Consent (PIC) Procedure for Certain Hazardous Chemicals and Pesticides in International Trade
www.pic.int/

The Convention on the Prevention of Marine Pollution by Dumping of Wastes and Other Matter
www.imo.org/Conventions/contents.asp?topic_id=258&doc_id=681
www.londonconvention.org

The Dublin Statement on Water and Sustainable Development
www.wmo.ch/web/homs/documents/english/icwedece.html

The Millennium Declaration of Johannesburg
www.johannesburgsummit.org/html/documents/summit_docs/political_declaration_final.pdf

Олон улсын форумууд ба тусгай дэгүүд

Өөрсдийнхөө эрхийн төлөөх тэмцэлд анхаарал хандуулахын тулд хүмүүс улс орнуудын дунд олон улсын хуулийн форумуудыг байгуулдаг. Жишээлбэл, Америкийн улсуудын Интер Америка шүүхийн байгууллага, Дэлхийн шүүх, НҮБ-ын хүний эрхийн комисс зэрэг. Эдгээр байгууллагууд нь улс орнуудад хүний эрхийн зөрчлөө багасгах, байгаль орчны хөнөөлийг багасгах талаар шахалт үзүүлж ийм хөнөөл үзүүлж байгаа гэрээ хэлэлцээр болон бизнесийн үйл ажиллагааг зогсоохыг шаарддаг.

Хүний эрх зөрчигдөж байгаа оронд шүүхэд зарга мэдүүлэх нь хэргийг шийдэж чадаагүй байж болох ч тухайн улс орны шүүх нь шударга бус гэдгийг нотолж чадвал энэ хэргээ олон улсын шүүхэд тайлбарлаж хянуулж болдог.

НҮБ хүний эрхийн зөрчлийн асуудлыг шийдвэрлэхийн тулд тусгай комиссуудыг байгуулдаг. Тэдгээр тусгай комиссууд нь засгийн газрын зөвшөөрөлгүйгээр тодорхой хэргийг авч үзэж болох бөгөөд ямар нэг конвенцээс хамаарахгүй шийдэж болно.

Хэрэв орон нутагтаа гарсан асуудлыг ийм тусгай комиссоор хэлэцүүлье гэж шийдвэл НҮБ-ын тусгай хүний эрхийн экспертүүдийг дуудаж асуудлаа шийдүүлж болно. Тэд хүний эрхийн зөрчлийг мөрдөн, тухайн орны хоол хүнс, хог хаягдал эрүүл мэндийг шалгаж, зөрчигдсөн эсэхийг мэдээлдэг. Хүний эрхийн төлөөлөгч нарт жирийн захиа бичиж болох ба түүндээ нотлох сурвалжлагын материал зэрэг баримтуудыг явуулж болдог. НҮБ-ын тусгай төлөөлөгч нар хүний эрхийн зөвлөл болон НҮБ-ын Ерөнхий ассамблейд тайлангаа тавьдаг. Тэдний бүрэн эрх, харилцах хаяг нь НҮБ-ын хүний эрхийн веб сайт дээр /www.ohchr.org/ “human rights by issue” гэсэн хаяган дээр байдаг.



Хавсралт С

Энэхүү хавсралтад орчны эрүүл мэндтэй холбоотой хэрэгтэй мэдээллийг нэмж өгч чадах байгууллагуудын нэр, тэдний хэрэглэсэн нэр болон интернетэд байгаа материалын жагсаалтыг орууллаа.

Бид энэхүү номондоо аль болохоор дэлхийн олон өнцгөөс, аль болох олон материалуудыг, олон сэдвээр оруулсан юм. Доор байгаа жагсаалт мэдээлэл нь энэхүү номонд байгаа мэдээллийг баяжуулна.

Сэдэв бүрээр та байгууллага, тодорхой ном, материал олж үзэж болно. Энд байгаа байгууллага нь орчны эрүүл ахуйн талаарх шууд ажилд тулалцаа үзүүлэх боломжтой юм. Мөн хэвлэмэл материал нь орчны эрүүл ахуйг сайжруулах гарын авлага номнууд юм. Ихэвчлэн хэвлэмэл материалуудад бусад эх сурвалжийг дурьдсан байгаа. Интернет орчны эрүүл мэндийн маш олон төрлийн асуудлуудыг агуулж байгаа. Бас танд олон арга зааж өгнө.

Орчны эрүүл мэнд ба шударга ёсны талаар сургалт явуулах

Training for environmental health and justice

Printed materials

Organizations

From the Roots Up: Strengthening Organizational Capacity through Guided Self-Assessment

International Institute for Environment and Development (IIED)

By Peter Gubbels and Catherine Koss

An international policy research institute that works with many groups, from smallholder farmers and big city slum-dwellers to national governments, regional NGOs, and global institutions to promote sustainable and equitable global development.

A guide to help grassroots organizations and community groups recognize their potential, identify critical issues, and decide for themselves what actions to take to build their capacity.

3 Endsleigh Street, London WC1H 0DD
Tel: +44 (0) 20-7388-2117
Fax: +44 (0) 20-7388-2826
E-mail: info@iied.org
Website: www.iied.org

World Neighbors
4127 NW 122nd Street, Oklahoma City,
Oklahoma 73120-8869, US A
Tel: +1-405-752-9700
Fax: +1-405-752-9393
E-mail: actionlearning@wn.org